

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

1. Үндсэн үйл ажиллагаа

Газрын үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байна. “Баян-Өндөр сум ЗДТГ-ын болзошгүй аваарын зардал”, “Эрдэнэт сан”, “Анхны-Оч ӨЭМТөв”, “Жаргалант сумын ЗДТГазар”, “Эрдэнэ ус ДТС” ОНӨХК зэрэг байгууллагуудын 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг гүйцэтгэж байна.

“Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сан”, “Дэгдээхэй цэцэрлэг, “23-р цэцэрлэг”, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар”-ын 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалтыг дуусгаж тус байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт зөрчил, дүгнэлтийг танилцуулж ажиллалаа.

Байгууллагын Эцэг эхийн зөвлөлийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсны дагуу “Түшиг ЭнЖиБи” ХХК-тай хамтран албан хаагчдын хүүхдүүдийг “Генетик тест”-ийн оношлогоонд хамруулсан.



Аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/257 дугаартай захирамжаар батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” ажлын хэсэг 2025 оны 04 дүгээр 23-ны өдөр байгууллагын 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллалаа.



2025.04.30-ны өдөр Аймгийн Дотоод аудитын хороог хуралдуулж дараах асуудлуудыг хэлэлцүүлээ. Үүнд:

МУЗГ-ын 2025 оны 37 дугаар тогтоолоор Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар болсонтой холбоотой “Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дүрэм”, “Дотоод аудитын журам”, “Санхүүгийн хяналт шалгалт хийх журам” -ыг хэлэлцүүлэн батлууллаа. Мөн 2025 оны Дотоод аудит, хяналт шалгалтын төлөвлөгөөний хүрээнд 2025.03.30-ны өдрийн байдлаар Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудын танилцуулга хийгдлээ.



2. Сургалт, зөвлөгөөн

- 2025.04.03-ны өдөр “Эрүүл мэндийн газар”-тай хамтран “Эрүүл шүд” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.



- 2025.04.03-ны өдөр “Насан туршийн суралцахуйн төв”-ийн Т.Мөнхчимэг багштай хамтран “Асуудлын мод”-ны аргыг сургалтад ашиглах нь, “Олны өмнө ярих, илтгэх аргад суралцах нь” сэдэв сургалтыг зохион байгуулсан.



- 2025.04.07-08-ны өдрүүдэд Монгол Улсын Их хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Ёс зүйн дэгийн байнгын хороо, Монгол Улсын Ёс зүйн хороо, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны салбар зөвлөлүүд хамтран зохион байгуулсан "Бүсчилсэн хөгжил - Төрийн албаны манлайлал" хойд бүсийн зөвлөгөөнд Байгууллагын дарга, Ахлах мэргэжилтэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн нар оролцлоо.



- 2025.04.09-ны Тагнуулын Ерөнхий газрын Орхон аймаг дахь газраас зохион байгуулсан "Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалт", "Кибер аюулгүй байдлын тухай хууль, холбогдох журмын хэрэгжилт" сэдэвт сургалтад Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн хамрагдлаа.
- 2025.04.10-11-ны өдрүүдэд Сангийн яамнаас зохион байгуулсан "Улсын салбарын дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөн" Хөвсгөл аймагт боллоо. Зөвлөгөөнд газрын дарга, ахлах мэргэжилтэн нар оролцсон.




- 2025.04.14-ны өдөр ХАБЭА-н сарын аяны төлөвлөгөөт ажил болох Аймгийн Улаан загалмайн хороотой хамтран "Анхан шатны тусламж үйлчилгээ" сэдэвт сургалт, дадлага ажлыг зохион байгууллаа.



- 2025.04.17-ны өдөр Хар тамхитай тэмцэх газар, Цагдаагийн газраас улсын хэмжээнд зохион байгуулж буй “Анзаар-2” нэгдсэн арга хэмжээнд байгууллагын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр хариуцсан албан хаагч оролцлоо.




- 2024.04.17-ны өдөр “Насан туршийн суралцахуйн төв”-тэй хамтран “Н-Form аргыг сургалтад ашиглах” сэдэвт дотоод сургалтыг зохион байгууллаа.



- 2025.04.18-ны өдөр аймгийн ИТХ-аас зохион байгуулсан “Гамшгийн эрсдэлийг бууруулахад орон нутгийн эмэгтэйчүүдийн оролцоо III аяны хүрээнд “Эрүүл эмэгтэй-Эрсдэлгүй гэр бүл” чуулга уулзалтад байгууллагын дарга, нягтлан бодогч, Гамшгийн хөтөлбөр хариуцсан албан хаагчид хамрагдлаа.



- 2025.04.24-ний өдөр Хүний эрхийн Үндэсний Комиссын Орхон аймаг дахь референт Ц.Батзаяа “Хүний эрх ба хүний эрхэд суурилсан хандлага” сэдэвт сургалтыг албан хаагчдад зохион байгууллаа.



САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР